





3	Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны тухай	5	12.20%
4	Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчийн ёс зүйн тухай	1	2.44%
5	Ажлаас чөлөөлөгдөх тухай	4	9.76%
6	Ажилд орох тухай	1	2.44%
7	Барилга байгууламжийн тухай	1	2.44%
8	Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай	1	2.44%
	Нийт өргөдөл, гомдлын дүн	41	100%

#### 4. Хариу өгсөн хэлбэрийн тайлан.

№	Хариу өгсөн хэлбэр	Тоо
1	Программ хангамж+ Мессежээр хариу өгсөн	33
2	Программ хангамж+ Мессежээр+утсаар хариу өгсөн	4
3.	Програм хангамж + Мессеж + Албан бичгээр хариу өгсөн	-
4.	Иргэнтэй биеэр уулзаж хариу хүргүүлсэн	6

#### 5. Шийдвэрлэсэн байдал

Шийдвэрлэсэн байдал	
Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл	41
Боломжгүй тухай хариу өгсөн өргөдөл	2
Бусад	-

6. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн нэгдсэн тайлан.

Ангилал	Нийт		Шийдвэрлэх шатандаа байгаа		Шийдвэрлэж хариу өгсөн	
	Тоо	Хувь	Хугацаа хэтэрсэн	Хугацаандаа байгаа	Хугацаандаа шийдвэрлэсэн	Бүгд
Байгууллагын нэр: СБНЭ	43	100 %	0	0	43	100,0 %
Нийт	43	100 %	0	0	43	100,0 %

7. Өргөдөл, гомдлын индексийн үнэлгээ: 0.95

8. Өргөдөл, гомдлын төрлийн тайлан

Байгууллага	Хүсэлт		Гомдол		Талархал		Санал		Нийт
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Байгууллагын нэр: СБНЭ	6	13.95 %	12	27,91%	25	56.10 %	-	-	43

9. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн нэгдсэн тайлан

43 өргөдөл ирсэнийг 100 % шийдвэрлэсэн.

10. Зөрчлийн тоон үзүүлэлт-0

Д/д	Ажил	Зөрчил		Нийт
		Тоо	Хувь	
1	2025	Явцын тэмдэглэл хөтлөөгүй		--
		Буцаалтыг 3 хоногт хийгээгүй		-
		Өдөрт нь багтаан шилжүүлээгүй		1
		Өдөрт нь багтаан хүлээн аваагүй		7
		Буруу шилжүүлсэн зөрчил		-

2025 оны өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчлийн тайлбарыг тухай бүр өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн Д.Нарантуулд хүргүүлсэн.

**11. Хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлын тайлан -0.0% - Байхгүй**

Төрөл: Байгууллага – СБНЭ

Бүлэг: Нийслэл, нэгж .

Ангилал:

- Өргөдөл, гомдол, саналын ирсэн хэлбэр нь:
- ННЗБ-аас 11 буюу 25.58 %
- Засгийн газрын 11-11 төвөөс 32 буюу 73.17 % -ыг эзэлж байна.

2025 оны 4 дугаар улиралд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой иргэдээс албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл гомдол, санал, хүсэлт, талархлыг 2024 оны 4 дугаар улиралтай харьцуулан үзэхэд:


№	Талархал	Гомдол	Санал	Хүсэлт
1	2024 оны 4-р улирал	58 буюу 71,60 %	21 буюу 25.93 %	1 буюу 1.23 %
2	2025 оны 4-р улирал	25 буюу 58.14 %	12 буюу 27.91%	0 буюу 0 %
				6 буюу 13.95 %

**2025 оны 4 дүгээр улиралд гомдолгүй ажилласан.**

Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой гарсан гомдлыг чанарын алба болон ёс зүйн хороогоор авч хэлэлцэн алдаа дутагдал гаргасан эмч, сувилагч, ажилтнуудад хугацаат үүрэг даалгавар өгч, мэдлэг мэргэжилээ дээшлүүлэн, дахин гомдол зөрчилгүй ажиллах талаар үүрэг даалгавар өгч хяналт хийн, бүтээлж ажлууд зохион байгуулан ажиллаж байна.

“Сүхбаатар” Нэгдсэн эмнэлгийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албанд үйлчлүүлэгчдээс ирсэн өргөдөл, гомдол, саналыг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01 сарын 25-ны өдрийн А/50 тоот “Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих журам”, “Сүхбаатар” Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 06 сарын 24-ний өдрийн А/96 дугаар тушаалаар “Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих журам батлах тухай” журмын дагуу бүртгэж, шийдвэрлэн ажиллаж байна.

Д/д	Гомдол	Талархал	Санал хүсэлт
1	12	25	6



Гомдлын мөрөөр хийсэн ажлын тайлан

Д/д	Гомдлын агуулга	Хийж хэрэгжүүлсэн бүтээлч ажил	Үр дүн
1.	<p><b>G250310075</b>      <b>2025.03.10</b></p> <p>СБД-ийн Хүүхдийн 2 дугаар эмнэлэгт сэхээнд хүн сахиж байгаа юм. Гэтэл автомашины зогсоол нь өдөрт 5000 төгрөг гарах юм бол цагийн 3500 төгрөг 5 хоноход 250 мянган төгрөг авч байлаа. Яагаад өвчтэй иргэний ар гэрээс төлбөр аваад байгаа вэ? Эмнэлгийн байгууллага шүү дээ. Эм тариандаа мөнгөө зарцуулмаар байна. Үүнийг болиулах хэрэгтэй байна. Ядаж сэхээнд байгаа иргэдийн ар гэрийг хөнгөлж болдоггүй юм уу?. Энэ асуудлыг холбогдох байууллагад нь уламжилж өгнө үү.</p>	<p>1. Гомдол гаргасан иргэн С.Оюунцэрэнтэй 86063500 дугаараар холбогдож асуудлыг тодруулж, биечлэн уулзсан</p> <p>2. Тухайн өдрийн харуул Энхсайхантай уулзаж тодруулга хийсэн</p> <p>3. 2025 оны 03 сарын 05-аас 03 сарын 10-ны өдрүүдэд 6 машины зогсоолын төлбөр төлсөн 250.000 төгрөгийг иргэн С.Оюунцэрэнд буцаан олгож гомдлыг шийдвэрлэлэсэн</p> <p><b>Бүтээлч ажил:</b></p> <p>1. Эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж буй үйлчлүүлэгчийн ар гэрийнхнээс машины зогсоолын төлбөрөөс чөлөөлсөн /журамд шинэчлэл хийсэн/</p> <p>2. Эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж буй үйлчлүүлэгчийн ар гэрээс журмын дагуу машины зогсоолын төлбөр аваагүй</p>	<p>1. Машины зогсоолын төлбөртэй холбоотой гомдол дахин гараагүй</p> <p>2. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж сайжирсан</p>
2.	<p><b>G250321077</b>      <b>2025.03.21</b></p> <p>СБД-ийн Нэгдсэн эмнэлгийн дотоод шүүрлийн эмч н.Удвалцэцэгт гомдол гаргаж</p>	<p>1. Иргэн Батжаргалтай 91923459 дугаарын утсаар холбогдож, биечлэн уулзаж асуудлыг тодруулсан.</p> <p>2. Иргэн Батжаргалыг өөрийн эмнэлэг дээр шаардлагатай шинжилгээнд бүрэн хамруулж, нарийн мэргэжлийн эмчид</p>	<p>1. Иргэн Батжаргал өөрийн биеээр ирж эмнэлгийн эмч ажилч-дад талархал илэр-хийлсэн</p> <p>2. Иргэнийг чирэгдүү-лэхгүйн тулд өвөрмөц шинжилгээг хаана хэрхэн хийгддэг тухай</p>

<p>байна. Энэ эмчид үзүүлээд шинжилгээ хийлгэх гэсэн боловч Ай Ти лабораторид хийлгэ, энд их үнэн гардаг гэж хэлж байна. ЭМД төлж байж хувийн эмнэлгээр үйлчлүүл-мээргүй байна. Энэ эмчийг лаборатори зааж өгөхийг болиулмаар байна. Холбогдох байгууллагад нь уламжилж өгнө үү?</p>	<p>үзүүлж дараагийн шатлалын эмнэлэгт явуулсан</p> <p><b>Бүтээлч ажил:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Нийт эмч нарт ЭМС-ын А/406 тоот тушаалын дагуу сургалт явуулсан</li> <li>2. ЭМС-ын 2023 оны 7014:2023 “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” стандартыг Ж.Удвалцэцэг эмч нийт эмч нарт сургалт явуулсан</li> <li>3. ҮАЭОД, ЭМТҮЧАБАлбатай хамтран тасаг нэгжүүдээр дэмжлэгт хяналт хийж, 154 үйлчлүүлэгчтэй уулзсан. Үүнд <ul style="list-style-type: none"> <li>• Эмнэлгийн тусламж үйлчил-гээний талаар мэдээлэл өгсөн</li> <li>• Сэтгэл ханамжийн судалгаа авсан</li> <li>• Эрүүл мэндийн ажилтан үйлчлүүлэгчийн хоорондын үр дүнтэй харилцааны талаар сургалт явуулсан</li> </ul> </li> <li>4. Лабораторийн гадаад, дотоод хяналтын талаар лабораторийн эмч Т.Сэлэнгэдэлгэр эмч нарын ярианд мэдээлэл хийсэн</li> </ol>	<p>зөв мэдээлэлийг өгдөг болсон</p> <p>3. Үйлчлүүлэгч болон эмчийн хооронд үр дүнтэй харилцаа бий болсон</p>
<p><b>3</b></p> <p><b>G250325077</b>    <b>2025.03.21</b></p> <p>СБД-ийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторид үзүүлэх гээд очиход эмч нар нь урьдчилан сэргийлэх үзлэг хийхээр явсан гээд эмч нар нь байхгүй байна. Нэг эмч үзлэг хийж байна,</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Иргэн Саруултуяатай 80848464 дугаараар холбогдож асуудлыг тодруулсан.</li> <li>2. Амбулаторийн эмч Г.Маралмаатай ярилцаж, асуудлыг тодруулсан</li> <li>3. 3 сарын 27 нд иргэн Саруултуяа ирж үзүүлж бүрэн шинжилгээнд хамруулан, оношийг тодруулж өгсөн</li> <li>4. ҮАЭОдарга Ө.Туул зөвлөгөө өгч, эмчилгээг шийдвэрлэсэн</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>1. Иргэн Саруултуяа эмчдээ талархал илэрхийлсэн</li> <li>2. Хүний нөөцийн зохицуулалт хийснээр үйлчлүүлэгчдээс гомдол гараагүй</li> <li>3. Үйлчлүүлэгчдийн чи-рэгдэл, хүлээгдэл гараагүй</li> </ol>

<p>дугаарлан олон цаг хүлээж байж үзүүлэхэд 112 тоотын бөөр мэдрэлийн эмч нь хангалттай үзлэг хийсэнгүй. Миний ходоодны шарх маш их өвдөлт өгч байхад, тухайн эмч нь цусны шинжилгээ өгөөд ирээрэй гээд өөр үзлэг зөвлөгөө өвчнийг намдаах арга ч хэлэхгүй гаргасан. Цусны шинжилгээ өгсөн ба уг шинжилгээний хариу нь ходоодны асуудлыг нарийн гаргахгүй гэж бодож байна. Хариу нь гартал миний өвдөлт маш их зовууртай хэцүү байна. Уламжлан шийдвэрлэж өгнө үү.</p>	<p>Бүтээлч ажил:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Урьдчилан сэргийлэх үзлэг давхацсан үед хүний нөөцийн зохицуулалт хийх зураглал гаргасан</li> <li>2. Амбулаторийн эмч Г.Маралмаатай уулзаж, үзлэгийн эмчийг нэмэлтээр томилж асуудлыг шийдсэн</li> <li>3. Г.Маралмаад сэтгэлзүйн зөвлөгөө өгч ажилласан</li> </ol>	<p>Бүтээлч ажил:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Иргэн П.Оюун-Эрдэнэ эмнэлэгээс гарахдаа талархал илэрхийлсэн</li> <li>2. Дахин гомдол гараагүй</li> <li>3. Лавлагаа мэдээллийн хөтөчийн үйл ажиллагаа сайжирсан</li> </ol>
<p>4.</p>	<p><b>G2503260673 2025.03.26</b></p> <p>03 дугаар сарын 25-наас 26-нд шилжих шөнийн 2 цаг зүрх өвдөж СБД-ийн Нэгдсэн эмнэлгийн хүлээн авах дээр очсон юм. Гэтэл эмч н.Энхтуяа нь унтаж байгаад нойрмог гарч ирээд маш сэтгэлгүй унтаагаараа үзэж, олигтой үзүүлсэн тус-ламжгүй маргааш амбулаторийн эмчдээ үзүүлээрэй гээд унтах</p>	<p>Бүтээлч ажил:</p> <ol style="list-style-type: none"> <li>1.Иргэний гомдлыг хүлээн авч үйл ажиллагаа эрхэлсэн орлогч дарга Ө.Туул П.Оюун-Эрдэнэтэй 99680406 дугаараар холбогдож асуудлыг тодруулсан.</li> <li>2. П.Оюун-Эрдэнэ өнөөдөр буюу 2025 оны 03 сарын 27-ны өдөр эмнэлэг дээр ирж шинжилгээ өгч, дотрын тасагт хэвтэн эмчлүүлсэн</li> </ol>

	<p>гээд яваад өгсөн. Тангараг өргөсөн эмч хүн яаралтай тусламж дээр ажиллаж байж ингээд унтаад байх ёсгүй гэж харж байна. Уламжлан арга хэмжээ авч өгнө үү.</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Яаралтай тусламжийн камер шүүхэд эмч тасагт тусламж үйлчилгээ үзүүлж байсан</li> <li>2. Жижүүр эмч Энхтуяатай уулзаж мэдээлэл авсан, тухайн үед тусгаарлах өрөөнд хүнд өвчтөнд тусламж үзүүлж байсан</li> <li>3. Хамт гарч буй жижүүрийн сувилагчид үйлчлүүлэгчид эмчийн талаар тодорхой мэдээлэл өгөх сургалт хийсэн</li> <li>4. Лавлагаа мэдээллийн хөтөчийн сургалтыг Хүний нөөцийн албанаас хийсэн</li> <li>5. Нийт эмч нарт эмч үйлчлүүлэгчийн харилцааны талаар сургалт хийгдсэн</li> </ol>	
<p>5. <b>G250417068</b> 2025.04.17</p> <p>СБД-ийн эмнэлгийн яаралтай тусламжийн 3 давхарт дотрын тасгийн сувилагч намайг маажаад зодоод байна. Энэ одоо одоо тангараг өргөсөн сувилагч мөн үү? Сувилагч нар нь цалингаа нэмье цалингаа нэмье гээд байдаг. Эмнэлэгт хүн хэвтүүлэхэд 300.000 төгрөг авдаг гэж байна. Энэ асуудлаа</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Иргэн Р.Наранчимэгтэй уулзаж асуудлыг тодруулсан</li> <li>2. Жижүүр эмч Ч.Хуунагваралтай уулзаж тухайн гомдлын дагуу тодруулсан</li> <li>3. Иргэн Р.Наранчимэг нь СЭМҮТ-ийн эмчийн байнгын хяналтанд байдаг.</li> <li>4. СЭМҮТ-ээс мэргэжлийн эмч дуудаж үзүүлэн F31 оношоор өөрийн эмнэлгийн машинаар СЭМҮТ- рүү шилжүүлсэн</li> </ol> <p><b>Бүтээлч ажил:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Дотрын тасгийн эмч нар оношийг маш хурдан хугацаанд тодруулж, нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө авч, шуурхай шийдвэрлэсэн</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>1. Иргэн Р.Наранчимэг-ийг хурдан мэргэжлийн шилжүүлсэн газарт</li> <li>2. Сургалт хийснээр сэтгэцийн өвчтөнтэй харилцахад мэдлэгтэй болсон</li> </ol>	

	<p>шийдэхгүй юм уу? Хологдох газар нь уламжилж өгнө үү.</p>	<p>2. Жижүүрийн хугацаанд сэтгэцийн эмгэгтэй хүн дотрын оноштой ирэхэд хугацаа алдалгүй шийдэх талаар сэрэмжлүүлэг өгсөн</p> <p>3. СЭМҮТ-ийн сувилахуйн албатай холбогдон сургалт авсан /сэтгэцийн эмгэгтэй өвчтөнтэй хэрхэн харилцах талаар/</p>	
<p>6. <b>G250418035</b>     <b>2025.04.18</b></p> <p>Иргэн СБД-ийн Хүүхдийн эмнэ-лэгт хэвтэж байхдаа хүүхдүүдээ дутуу эмчлүүлсэн талаар гомдол гаргахыг хүсэж байна. Хоёр хүн 3 хүүхдээ авч хэвтэн эмчлүүлсэн. Тэрээр эмнэлгийн 3 давхрын тасгийн ажилтнуудын харьцааны доголдол, эмчилгээний асуудлыг хөндөж, цаашид хүүхдүүд нь хүндрэх тохиолдолд хаана хандах талаар асууж байна. Уян зүүгээр тариа нь явахгүй байхад ирж харахгүй мөртөө аваад ир гээд хүнд суртал гаргасан. Энэ асуудалд гомдолтой байна.</p>	<p>1. Иргэн Лхагвадуламын ирүүлсэн гомдлыг чанарын алба судалж асуудлыг тодруулсан</p> <p>2. Хүүхдийн тасгийн эмч сувилагч нартай холбогдож асуудлыг тодруулсан</p> <p>3. Нэг гэр бүлийн 7 хүн дотор, хүүхдийн тасагт эмчлэгдэж байсан. Үүний улмаас тасаг хооронд холилдож, хоол цайгаа зөөсөн үйлчлүүлэгч эмнэлгийн хооронд учир үйл ойлголцол гарсан</p> <p>4. Тухайн үед хүүхдийн тасагт улаанбурхан өвчний сэжигтэй тохиолдол гарч ХӨСҮТ-рүү шилжүүлсэн учир хөдөлгөөн түр хугацаанд хорьсон байсан</p> <p>5. Иймээс хүүхдийн тасаг руу олон удаа орж болохгүй эрсдэлтэй сувилагч, асрагч нар шаардлага тавьсан.</p> <p>Бүтээлч ажил:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Эмнэлгийн дотоод журамд үйлчлүүлэгчийн эрх үүргийг тодорхой ил тод байрлуулсан</li> <li>2. Халдварт өвчний дэгдэлтийн үед үйлчлүүлэгч бүрт эмнэлэгт халдвар хамгаалах дэглэм барих талаар сургалт хийсэн</li> <li>3. Уян зүүг хэрхэн хамгаалах талаар тархвар судлалын эмч нар хүүхдийн</li> </ol>	<p>1. Тухайн үйлчлүүлэгч нар эмнэлэгт эмчлэгдээд гарсан</p> <p>2. Гомдолгүй гэсэн</p> <p>3. Цаашид хүүхдийн тасагт эмнэлгийн дотоод журмыг үйлчлүүлэгч хангаж ажиллаж байна</p> <p>4. Халдварт өвчний дэгдэлтийн үед үйлч-лүүлэгч нарт халдвар хамгааллын дэглэм барих талаар гарын авлага тарааж байна</p>	

7	<p><b>Бичгээр ирсэн гомдол</b></p> <p>12 тоот өрөөний эмч Маралмаа эмч дээр үзүүлж танай эмнэлэг дээр орой болгон тариа хийлгэж байна. Танайд хэвтэх гэсэн чинь хэвтэх шаардлагагүй байна гээд ярьж байсан. Манай ээж гараад явсан. Яагаад ээж чинь гараад явчихав гэсэн чинь гомдчих шиг боллоо гэсэн. Өөрсдөө өвдөж ирчихээд юундаа уурладаг юм гэж загнасан. Цаад талд нь сууж байсан эмч нь наадхаа жорыг нь бичээд явуулаач гэсэн. Тэгээд битгий уурлаад бай гар гэсэн. 2 эмч нь нийлж загнасан Маралмаа эмч нь би та нарыг өвтгөсөн юм уу гэж загнасан. Энэ эмчдээ анхааруулж өгнө үү Гомдол гаргасан охин Даариймаа Утас-98667741, 86131126</p>	<p>тасагт дэмжлэгт хяналт хийж арга зүйн зөвлөгөө өгч ажилласан</p> <p>1. Эмч Г.Маралмаагаас асуудлыг тодруулсан</p> <p>2. Иргэн Л.Тунгалагтай уулзаж асуудлыг тодруулсан</p> <p>3. Эмч үйлчлүүлэгч нарын хооронд үйл ойлголцол үүссэн байсан</p> <p>4. Иргэн Л.Тунгалагийг ДМТ-т хэвтүүлж, 6 хоног эмчлүүлж биеийн байдал сайжирч гарсан.</p> <p>Бүтээлч ажил:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Эрэмблэн ангилал яаралтай тусламжийн талаар их эмч Б.Дугар эмч нарт сургалт явуулсан</li> <li>2. Хэцүү үйлчлүүлэгчтэй хэрхэн харилцах талаар чанарын албанаас сургалт хийсэн</li> <li>3. Амбулаториор ирж буй үйлчлүүлэгчдэд ор зохицуулах эмч шаардлагатай тохиолдолд /хэцүү үйлчлүүлэгч/ чанарын албанд мэдээлж зохицуулалт хийх</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>1. Иргэн Л.Тунгалаг эмнэлэгээс гарахдаа илэрхийлсэн талархап</li> <li>2. Хэцүү үйлчлүүлэгчтэй харилцах талаар мэдлэгтэй болсон</li> <li>3. Залуу эмч нар багаар ажиллах чадвартай болсон</li> </ol>
8	<p><b>Бичгээр ирсэн гомдол</b></p> <p>Үйлчлүүлэгч Г.Энхтуяа 05 сарын 01-ний өглөө эрт ирж</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Үйлчлүүлэгч Г.Энхтуяагаас асуудлыг тодруулсан</li> <li>2. Тухайн гомдолтой холбоотой эмч нартай уулзаж тодруулсан</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>1. Үйлчлүүлэгч Г.Энх-туяа эмнэлэгээс гарах-даа гомдолгүй гэсэн</li> <li>2. Эмнэлэгт хэвтэж байгаа үйлчлүүлэгч нарт гарын</li> </ol>

<p>эмнэлэгт хэвтсэн. Өдөр 14 цагт ор олж орсон. 05 сарын 03-ны өглөөнөөс эхлээд 5 өдөр эмчилгээ хийлгээд гарлаа. Эмчид хэлсэн би эмчилгээг оруулсан гээд сувилагч ороогүй байна гээд 1 өдрийн дараа буюу 3-аас эхэлсэн. Би анх орж ирэхдээ Дотоод шүүрлийн эмчид үзүүлбэ гэж орж ирсэн. Анужин эмчид Чихрийн бус шижинтэй ухаан алдаж унадаг, маш их шээж шөрмөс татаж ирсэн. Эмнэлэгт хэвтэж байхдаа хавангийн тариа хийгээд шөрмөс татаж эхэлсэн. Эмнэлэгт хэвтсэнээс хойш ганц ч унтаагүй. Зүрх дарж байгаа юм шиг болоод зүрх дэлсээд эмчид хэлсэн боловч эмч тоогоогүй. Эм тариа хийхдээ сувилагч нар сайн тайлбарладаг. Эм зүйч нар эм тариаг огт талбарлаагүй, эмч эм тариаг огт хэлдэггүй.</p> <p>Утас - 85226878</p>	<p>3. 5 хоног эмчлэгдээд биеийн байдал сайжирч эмнэлэгээс гарсан</p> <p><b>Бүтээлч ажил:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Үйлчлүүлэгчид өвчний талаархи зөвлөмж өгөх гарын авлагыг дотрын тасагт байрлуулсан</li> <li>2. Эмчилгээний талаар эмч үйлчлүүлэгчид бүрэн мэдээлэл өгөх талаар чанарын албанаас сургалт хийсэн</li> <li>3. Эмч нарыг эмнэлзүйн удирдамжийг мөрдөж ажиллах заавар, зааварчилгаа өгч ажилласан</li> <li>4. Эм зүйн албанд иргэн Энхтуяагийн гомдлыг танилцуулж үйлчлүүлэгчдэд эм тарианы үйлчилгээ болон зааврыг тогтмол танилцуулж хэвших үүрэг өглөө.</li> </ol>	<p>авлагыг тарааснаар өвчнийхээ талаар мэдлэгтэй болсон</p> <p>3. Эм зүйч нар эм тарианы талаар тогтмол танилцуулж хэвшсэн</p>
<p>9.</p>	<p>1. Иргэнийн гомдлыг хүлээн авч, ҮАЭОрлогч дарга Туул иргэн Б.Ундаръяатай 80784422</p>	<p>1. Иргэн Б.Ундаръяа гомдолгүй гэсэн</p>

	<p>СБД-ийн нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн хүүхдийн эмч н.Отгонбумбад гомдол гаргаж байна. Хүүхдээ үзүүлэх гээд ирсэн хүмүүсийг гадаа өнгө үзэмжээр нь ялгаварлаж, хүүхдэд эм бичиж өгөхгүй зөвхөн лаа бичээд дээрээс нь хэл амаар доромжилж байна. Энэ асуудлыг холбогдох газарт нь уламжилж өгнө үү.</p>	<p>дугаараар холбогдож асуудлыг тодруулан ярилцлаа.</p> <ol style="list-style-type: none"> <li>2. Жижүүрийн эмч Э.Отгонбумбаас асуудлыг тодруулсан</li> <li>3. 2025 оны 6 сарын 04 ний шөнө тус нэгдсэн эмнэлгийн хүүхдийн хүлээн авахаар 28 хүүхэд ирж, эрэмблэн ангилал хийж тусламж үзүүлсэн</li> <li>4. Тухайн үед хүүхдийн биеийн байдал дунд зэрэг, халуунгүй байсан учир очерын дарааллаар үзсэн</li> <li>5. Үйлчлүүлэгч антибиотик бичиж өгөхийг эмчээс шаардсан, эмч үзээд антибиотик шаардлагагүй гэж үзэн зөвлөөгүй</li> </ol> <p><b>Бүтээлч ажил:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Иргэн Б.Ундаръяад хүүхдийн өвчний талаар тайлбарлаж ойлгуулсан</li> <li>2. Эцэг эхчүүдэд антибиотикийн хэрэглээний талаар мэдээлэл, гарын авлагаар хангасан</li> <li>3. Хэцүү үйлчлүүлэгчидтэй харилцах талаар эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт хийсэн</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>2. Эцэг эхчүүдэд ЭМБО сургалтыг тогтмол-жуулсан</li> <li>3. Хүүхдийн эцэг эхчүүдэд аюултай ерөнхий шинжийн талаар ойлголтыг өгдөг болсон</li> </ol>
10.	<p><b>G250606072 2025.06.06</b></p> <p>СБД-ийн нэгдсэн хүүхдийн 2 дугаар эмнэлгийн рентген тасаг ажиллахгүй байна. Рентген тасаг эвдэрч, удаан хугацаанд ажил-лахгүй байгаа</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Иргэн Э.Эрдэнэтуяатай 91391616 дугаараар холбогдоход гомдол биш, санал хүсэлт гэж хэлснийг 11-11 рүү эргэн мэдэгдсэн</li> <li>2. Рентгены эмч Э.Амартүвшингээс асуудлыг тодруулахад рентген аппаратын засвар үйлчилгээ хийгдэж байсан</li> </ol> <p><b>Бүтээлч ажил:</b></p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Иргэн Э.Эрдэнэтуяа нь миний зүгээс гомдолгүй, санал хүсэлт байсан гэдгээ хэлсэн.</li> <li>2. Миний саналыг хүлээж авсанд танай эмнэлэгт баярлалаа гэж утсаар мэдэгдсэн</li> </ol>

	<p>Нь хатгаа авсан хүмүүсийн эмчилгээ хийгдэхгүй, зураг авхуулахад хүндрэл учруулж байна. Асуудлыг шийдвэрлэж өгнө үү.</p>	<p>1. Иргэн Э.Эрдэнэтуяад рентгены аппаратын засвар үйлчилгээний талаар ойлгуулсанп 2. 11-11 рүү гомдол биш санал байна гэдгийг эргэн мэдэгдсэн</p>	
11.	<p><b>G251105010</b>      <b>2025.11.05</b></p> <p>СБД-ийн хүүхдийн -2 хэвтэн эмчлүүлэх, эмнэлэгт шинжилгээ өгөхөөр 8:30 цагт иртэл шинжилгээ авдаг хүн нь ирээгүй байсан, хүлээж байгаад өгөх гэтэл нэр чинь ороогүй гээд, 8:35 цагт цахим дээр очоод дахиад шинжилгээ бичүүлээд очтол 15-20 минутын дараа баталгаажиж ордог нэр чинь ороогүй байна гээд, нааш, цааш явуулаад хүндрэл чирэгдэл учруулаад байна. Энэ асуудлаар гомдол гаргаж байна. Арга хэмжээ авч өгнө үү.</p>	<p>1. Иргэн Н.Регзэдмаатай 95085589 дугаараар хобогдож асуудлыг тодруулан ярилцлаа. 2. Тухайн гомдолтой холбоотой эмч нартай уулзаж тодруулсан. 3. Бүтээлч ажил: 1. Эмч нарт дахин ийм тохиолдол гаргахгүй байхыг сануулж, арга зүйн зөвлөгөө өгөв. 2. Үйлчлүүлэгчийн гомдлыг барагдуулхаар эмнэлэгт хэвтэх асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэв</p>	<p>Үйлчлүүлэгчтэй утсаар холбогдож болсон явдлыг тодруулж, холбогдох эмч нарт үйлчлүүлэгчийн гомдлыг танилцуулж дахин ийм тохиолдол гаргахгүй байхыг сануулж, арга зүйн зөвлөгөө өгч үйлчлүүлэгчтэй ойлголцов.. Үйлчлүүлэгчийн гомдлыг барагдуулсан.</p>
12.	<p><b>G251110084</b>      <b>2025.11.0</b></p> <p>Сүхбаатар дүүргийн яаралтай тусламжийн тасагт гомдол гаргах нь. Манай ихэр хүүхдийн тариаг хийж</p>	<p>1. Иргэн Н.Билэгт-Отгонтой 89181189 дугаа-раар хобогдож асуудлыг тодруулан ярилцлаа. 2. Тухайн гомдолтой холбоотой эмч нартай уулзаж тодруулсан. <b>Бүтээлч ажил:</b></p>	<p>Дүүргийн эмнэлгийн хүлээн авах яаралтай тусламжийн ажиллах хууль тушаал, эмнэлгийн дотоод журмыг</p>

	<p>өгсөнгүй. Гаднаас тариа хийдэггүй гэж хэллээ. Гомдолтой байна. Холбогдох байгууллагад нь уламжилж өгнө үү.</p>	<p>3. Үйлчлүүлэгчдэд баталгаагүй, эмчийн бичиггүй тариа хийхгүй талаар сануулга, мэдээлэл, гарын авлагаар хангасан</p>	<p>танилцуулж баратдуулав. ГОМДЛЫГ</p>
--	---	--	--

СҮХБААТАР НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ  
ХЯНАСАН:

ТАЙЛАН ГАРГАСАН:  
БИЧИГ ХЭРЭГ, АРХИВЫН ЭРХЛЭГЧ



Б.БАТЧИМЭГ

С.ОЮУНТУЯА